



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/50

Улаанбаатар хот

Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, "Журам батлах тухай" Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн албан хаагчийн албан томилолтын хоолны зардлыг суманд 30,000 төгрөг, аймгийн төвд 40,000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 50,000 төгрөгөөр, байрны зардлыг суманд 60,000 төгрөг, аймгийн төвд 130,000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 150,000 төгрөгөөр тус тус шинэчлэн баталсугай.
2. Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчийн байр, хоолны төсвийг тухай бүр баталсны үндсэн дээр олгохыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт зөвшөөрсүгэй.
3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

Б.ЖАВХЛАН

9763000148